

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000021211

2006.05.05

/Бүртгэсэн он, сар, өдөр/

9070001042

/Улсын бүртгэлийн дугаар/

9128727

/Регистрийн дугаар/

Цаг уур орчны шинжилгээний газар

Төрийн байгууллага, албан газар, улсын  
төсөвт үйлдвэрийн газар

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тогтоол

/шийдвэрийн нэр/

253

/дугаар/

1996.10.10

он, сар, өдөр

731000

/код/

Ус цаг уур, орчны шинжилгээ, төв, орон нутгийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар  
хангах

/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй

хугацаа

1

/Гишүүдийн тоо/

1,805.9

/Өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Чингэлтэй, 4-р хороо, Жуулчны гудамж, ЦУОШГ - ., утас1:99118719, утас2:11-326592, факс:

/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн  
этгээдийн бүртгэлийн газар

/бүртгэсэн байгууллагын нэр/

Гэрчилгээг дахин олгосон: 2011 он 06 сар 15 өдөр

**Харилцах банкны бүртгэл:**

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн  |                 |
|----------------------|--------------|---------------|------------|-----------------|
|                      |              |               | Огноо      | Ажилтан, тэмдэг |
| Төрийн сан           | Төгрөгийн    | 900013005     | 2006.05.05 | Я.Сүрэн         |

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:**

| Д/д | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга                                                                               | Бүртгэсэн  |                 |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------------|
|     |                                                                                                           | Огноо      | Ажилтан, тэмдэг |
|     | Энэ хуулийн этгээдэд 2006.05.05 өдөр олгосон гэрчилгээг хүчингүйд тооцож, гэрчилгээг дахин олгосон болно. | 2011.06.15 | В.Хандсүрэн     |
| 2   | Эрхэмбаяр овогтой Баттулга-г Дарга -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.                                      | 2025.04.21 | Д.Баяржаргал    |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.  
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол улсын Ус цаг уур, орчны шинжилгээний газар /цаашид газар гэх/ нь ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээг зохион байгуулж, уур амьсгал, гадаргын болон гүний усны нөөц, горимын зүй тогтолыг илрүүлэх судалгаа явуулах, цацраг идэвхжил, агаар, ус хөрсний бохирдлын төлөв байдлыг тасралтгүй хянаж, төр, засгийн удирдлага, төрийн захиргааны төв байгууллага, холбогдох агентлаг, байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах үндсэн зорилттой төрийн захиргааны байгууллага /засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг/ мөн.

1.2 Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Байгаль орчны сайд /цаашид сайд гэх/ -ын тушаалаар баталж мөрдүүлнэ.

1.3 Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4 Газар нь тогтоосон журмын дагуу хийсэн тамга, тэмдэг албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Газар нь өөрийн үйл ажиллагааны чиглэл, ажлын онцлог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн билэгдлийн ялгах тэмдэг /эмблем/-тэй байж болно.

1.5 Газар нь банкинд төгрөгийн харилцах данстай байна.

**Хоёр. Газрын удирдлага, эрх, үүрэг**

2.1 Газрын даргыг хариуцсан сайдын саналыг үндэслэн Монгол улсын Ерөнхий сайд, орлогч даргыг газрын даргын санал, Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн эрхэлсэн сайд тус тус томилж чөлөөлнө.


2.2 Газрын дарга нь газрын эрхэм зорилгыг хэрэгжүүлэх, удирдах дээд байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах үүргийг хариуцсан сайдын өмнө бүрэн хариуцаж ажлынхаа явц, үр дүнгийн талаар сайдын зөвлөлийн хуралдаанд хагас, бүтэн жилээр тайлагнана.

2.3 Газрын дарга нь Дэлхийн цаг уурын байгууллага дахь Монгол улсын байнгын төлөөлөгч байна.

2.4 Газрын дарга нь дор дурьдсан чиг үүрэгтэй ажиллана. Үүнд:

а/ газрын өдөр дутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

20



б/. газрын дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, цалин хөлсийг тогтоох;

в/. газрын дотоод бүтцийн нэгжүүдийн удирдлага, ажилтнуудыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

г/. газрын харъяа мэргэжлийн байгууллагуудын дүрэм, орон тоог батлах, даргыг нь зохих журмын дагуу томилох, чөлөөлөх;

д/. газрын нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах, хамтран ажиллах, газрыг гадаад, дотоодод төлөөлөх;

е/. газрын батлагдсан төсвийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах;

ж/. эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал, шийдвэр гаргаж, биелэлтийг хангуулах;

з/. газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр төр засгийн удирдлага, хариуцсан сайд, Байгаль орчны яамыг тухай бүр хангаж байх;

и/. газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гарсан хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын шийдвэр, эрхэлсэн сайдын тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах.

## 2.5 Газар нь доорх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

а/. газар нь Дэлхийн цаг уурын байгууллагын өмнө үндэсний ус цаг уурын албаны үүрэг гүйцэтгэхээс гадна Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн орчны хяналт-шинжилгээ, мэдээллийн сан, байгалийн гамшигтай холбоотой заалтын биелэлтийг хангуулж, агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны үүргийг гүйцэтгэх;

б/. улс орны хэрэгцээ шаардлага, Монгол улсын олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийг биелүүлэх үндсэн дээр ус цаг уур, орчны шинжилгээний албыг хөгжүүлэх урт, богино хугацааны хөтөлбөр, төсөл үзэл баримтлал зэрэг бодлогын баримт бичиг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх;

в/. ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээний ажлын хөтөлбөр боловсруулах, сүлжээний нэгжийг байгуулах, шилжүүлэх, татан буулгах;

г/. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төв, орон нутгийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахын хамт багаж тоног төхөөрөмж, сэлбэг материалаар улсын хэмжээнд төвлөрсөн журмаар хангах;

д/. ус цаг уур, орчны ажиглалт шинжилгээ, мэдээлэл боловсруулах, дамжуулах, архивлах, ус цаг уур орчны мэдээллээр төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдийг /цаашид хэрэглэгч гэх/ хангах аргачлалыг Монгол

24



улсын хууль тогтоомж, Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу боловсруулж мөрдүүлэх;

е/. ус цаг уур, орчны мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай үйлчлэх, байгалийн гамшиг, орчны бохирдлоос сэрэмжлүүлэх арга хэмжээ авах;

ж/. албаны хэмжээнд боловсон хүчний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, боловсон хүчнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, төрийн сангийн зардлаар оюутан сургах гэрээ хийх, тэднийг хэрэгцээтэй газар нь хуваарилан ажиллуулах асуудал хариуцах;

з/. салбарын хэмжилзүйн албыг зохион байгуулж ус цаг уур орчны шинжилгээний багаж төхөөрөмжинд хэмжилзүйн шалгалтыг хийх, эталон багажуудыг бүсийн болон олон улсын харьцуулалтанд оруулж баталгаажуулж байх;

и/. ус судлал, цаг уурын шинжилгээ, байгалийн түргэн хувьсах нөөцийн тандан судалгаа, орчны бохирдол, цацраг идэвхжил, хөдөө аж ахуй болон био цаг уурын нөөц, байгалийн гамшигт үзэгдлийн талаар эрдэм шинжилгээ, туршилт, хайгуул судалгааны ажил эрхлэн явуулах, энэ чиглэлээр улсын захиалгат ажил гүйцэтгүүлж үр дүнг нь хүлээн авах;

к/. ус цаг уур, орчны ажиглалтын улсын сүлжээ болон сүлжээнээс гадуур хийж буй ус судлал, цаг уур, орчны ажиглалтын бусад мэдээллийг ус цаг уур, байгаль орчны мэдээллийн санд оруулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах ажиллагааны технологийг боловсронгуй болгох ажлыг зохицуулах;

л/. байгаль орчны мэдээллийн улсын нэгдсэн сангийн технологийн асуудлыг эрхлэж мэдээллийн төрөлжүүлсэн болон орон нутгийн санг бүрдүүлэхэд мэргэжлийн зөвлөлгөө өгөх;


м/. иргэд, аж ахуйн нэгж байгууллагын суурин эх үүсвэр, тээврийн болон хөдөлгөөнт бусад эх үүсвэрийн төрөл тус бүрээс байгаль орчинд гаргах бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох ажлыг зохион байгуулах;

н/. хүлцэх хэмжээ нь улсын стандартаар хараахан тогтоогдоогүй бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийг агаарт гаргах түр зөвшөөрөгдөх дээд хэмжээг тооцон гаргаж байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулж баталгаажуулах;

о/. Дэлхийн цаг уурын байгууллагын конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц, Озоныг задалдаг бодисын тухай Монреалийн протоколын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

ё/. төрийн өмч хөрөнгийг хамгаалж, үр ашигтай зарцуулж, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэх.

25



## 2.6. Газар нь дараах эрхийг эдлэнэ. Үүнд:

а/. ус цаг уур, орчны мэдээллийг гадаад, дотоодын солилцоонд оруулахад харилцаа холбооны хэрэгсэл, суваг түрээслэн ашиглах, өөрийн холбооны сүлжээ байгуулан ажиллуулах;

б/. ус цаг уур, орчны шинжилгээний ажлын чиглэлээр холбогдох албан тушаалтны сонголт, мэдээллийг авч хэлэлцэх;

в/. улс орны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн цаг агаарын үзэгдэлд зориудаар нөлөөлөх ажил зохион байгуулах, үүнтэй холбогдсон зөвшөөрөл олгох;

г/. холбогдох байгууллагын гаргасан шийдвэр нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын талаар дагаж мөрдөж буй Монгол улсын хууль тогтоомжийг зөрчиж байвал түүнийг өөрчлүүлэх саналаа холбогдох дээд шатны байгууллагад нь тавих, түр түдгэлзүүлэх;

д/. ус цаг уур, орчны шинжилгээний асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд гэрээ хэлэлцээр байгуулах;

е/. ус цаг уур орчны шинжилгээний албаны материаллаг баазыг бэхжүүлэх, багаж төхөөрөмжийн хангамж, ажиллагсадын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

ж/. озоныг задалдаг бодис, хүлэмжийн хийн эх үүсвэрийн жагсаалт гаргах, улсын тоо бүртгэлийг явуулах, энэ тухай мэдээллийг гаалийн болон үйлдвэр, аж ахуйн байгууллага, иргэд, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас шаардан гаргуулах;

з/. цацраг идэвхжил, химийн хордлого үүссэн, осол гарсан, агаар ус, хөрсний бохирдол ноцтой ихэсч тэр нь хүний эрүүл мэнд, ургамал амьтны аймагт хор учруулахаар бол холбогдох аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны технологийн горимыг өөрчлөх, ажлыг нь бүрмөсөн зогсоох, гарсан хохирлыг арилгах санал боловсруулж холбогдох дээд байгууллагад тавих;

и/. иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас үйлдвэрлэлийн хаягдал, бохирдлыг хянах, хэмжих тоног төхөөрөмжийн стандартын шаардлага хангасан байдалд хяналт тавих, шалгалт хийх, стандартын бус төхөөрөмж, хэмжлийн аргыг хориглох саналаа байгаль орчны бүх шатны байгууллагад тавих;

2.7 Газар нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд хамрах зарим ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр бусад байгууллага, албан тушаалтнаар гүйцэтгүүлж болно. Ингэхдээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар тогтооно.

## Гурав. Газрын зохион байгуулалт

3.1 Газар нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр зохион байгуулагдсан аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төв, ус

26



5  
цаг уур, орчны ажиглалтын улсын сүлжээнээс бүрдсэн зохион байгуулалттайгаар ажиллана.

3.2 Төрийн үйлчилгээний дараах байгууллагууд ажил төрлийн хувьд газрын шууд удирдлаганд ажиллах бөгөөд алба нь аргазүй, мэргэжлийн удирдлага, хяналт шалгалтын ажлыг эдгээр байгууллагуудаараа дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд

- Ус цаг уурын хүрээлэн
- Мэдээлэл тооцооллын төв /цаг уурын холбооны болон зайнаас тандан судалгааны үндэсний төв/
- Байгаль орчны шинжилгээний төв лаборатори
- Нислэгийн цаг уурын төв
- Улаанбаатар хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төв
- Багаж үйлдвэрлэл-худалдааны төв

3.3 Газрын өмнө тавигдсан зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргахад газрын даргад зөвлөх эрхтэй зөвлөлийг байгуулж ажиллуулна. Газрын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын даргын тушаалаар батлана.

3.4 Газарт өдөр тутмын ажлыг зохион байгуулах үүрэг бүхий төрийн захиргааны цомхон аппарат ажиллах бөгөөд орон тоог Засгийн газраас өгсөн чиглэлийн хүрээнд Сайд тогтооно.

3.5 Газрын дэргэд ажиглалт-аргазүй, техникийн, мэдээлэл үйлчилгээ зэрэг технологийн асуудал эрхэлсэн ажлын комиссууд ажиллана. Комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын даргын тушаалаар батална.

3.6 Аймаг /нийслэл/ -ийн ус цаг уур орчны шинжилгээний төвийн захирлыг Газартай зөвшилцсөний үндсэн дээр аймаг /нийслэл/-ийн Засаг дарга, сум, багийн ус цаг уурын байгууллагын удирдлагыг аймаг /нийслэл/-ийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн захиралтай зөвшилцсөний үндсэн дээр тухайн шатны Засаг дарга тус тус томилно.

### Дөрөв. Газрын санхүүжилт, өмч хөрөнгө

4.1 Газрын санхүүжилт нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улсын төвлөрсөн төсөв /аппаратын болон арга хэмжээний зардал/
- Байгаль хамгаалах сан болон бусад сангаас ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд зориулан зарахыг зөвшөөрсөн хөрөнгө
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн аж ахуйн үйл ажиллагаа, үйлчилгээний төлбөрөөс орох орлого
- бусад эх үүсвэр

4.2 Газар нь өөрийн мэдлийн өмч хөрөнгөтэй байж түүнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

--- оОо ---

27

